

МОНГОЛЫН ТҮҮХЭН ДЭХ ЭХ ДАГИНАС

М. Зэнээ

Хүн төрөлхтний ариун Хэвлий, алтан сав болсон Эх хүн, тэдний нийгэмд гүйцэтгэсэн үйлс, тэсвэр тэвчээр, эх оронч халуун сэтгэл, үр хүүхдээ сурган хүмүүжүүлэх их эв дүй, уужим тэнүүн ухаан бодол, чин үнэнч хайр дурлал, хүнлэг энэрэнгүй ёс суртахууны үлгэр жишээг магтан дуулаагүй ном зохиол, уран бүтээл дэлхий ертөнцөд байдаггүй билээ.

Монгол үндэстэн үүсэн бүрэлдэж, түүхийн урт замыг туулж, төр ёсны их уламжлалаа өнөөг хүртэл хадгалж ирсэн бүх түүх Эх хүнтэй холбоотой. ХШ зууны үед зохиогдсон Монголын түүх, уран зохиол, хэлний гайхамшигт дурсгал бичиг «Монголын нууц товчоо» болон бусад сурвалж бичигт Монгол үндэстний түүхэнд нэр алдраа мандуулсан Их Богд эздийг төрүүлж, өсгөж, хүмүүжүүлсэн алдар цуут эх олон байсныг тодотгон гаргах, тэдний гавьяа зүтгэлийг хүндлэн дээдлэх нь бидний үүрэг мөн. Монголын түүхийн сурвалжаас үзвэл түүхэнд нэрээ мөнхжүүлсэн Эх дагина хэд хэд байдаг бөгөөд Үүнд Алун Гоо, Өэлүн үжин, Бөртө үжин, Мандахай Сэцэн зэрэг эмэгтэйчүүд зүй ёсоор орно.

Монгол үндэстний нэгтгэж, задрал бутралыг таслан зогсоох улс төрийн тэмцлийн ээдрээ төвөгтэй хүнд үед амин хувийн биш, ард түмнээ гэх чин халуун эх оронч сэтгэлээр үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлж, шулуун шудрага, сэцэн мэргэн оюун ухаанаараа ялгаран товойж, түүхийн хуудаснаа баларшгүй мөрийг үлдээн, ард түмний сэтгэл зүрхэнд өнө үүрд хадгалагдан үлдсэн дээрх эмэгтэйчүүдийг Монголын түүхэн дэх «Эх дагинас» гэж нэрлэх ёстой. Учир нь, тэд монгол туургатныг нэгэн захиргаанд нэгтгэх их үйлсэд бие сэтгэлээ зориулсан Богд эздийг төрүүлж, өсгөж, хүмүүжүүлсэн гавьяатай билээ. Монгол угсаатны түүхэнд монгол аймгуудыг нэгтгэн хан ширээнд суусан Бодончар богд, Чингис богд, Өгэдэй хаан, Батмөнх Даян хаан нарыг төрүүлж өсгөсөн буюу хүмүүжүүлсэн урианхайн Алун-Гоо, Олхуноудын Өэлүн үжин, Хонгирадын Бөртэ үжин, Түмэдийн Мандухай Сэцэн нарын гол онцлог бол үр хүүхэд, залгамж үеэ сайн хүмүүжилтэй ухаан бодол уужим, төрийн түвшин нуруутай, хоорондоо эе эвийг туйлаас эрхэмлэх, гадны дайснаас эх орноо нүдний цөцгий мэт хамгаалах үзэл санаагаар хүмүүжүүлэхэд ухамсарт бүх амьдралаа зориулж чадсанд оршино.

Хори Түмэдийн Ариг ус буюу одоогийн Хөвсгөл аймгийн Чандмана-Өндөр сумын нутагт байх Ариун голд¹, Хорилардай мэргэний Баргужин Гоо хатнаас төрсөн Алун-гоо нэрт төгс үзэсгэлэнт охин Чингис хааны өмнөх 11-р үеийн өвөг дээдэс Добу мэргэнтэй Бурхан халдун уулын нутагт гэрлэж Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр хүү төрүүлж билээ.² Добу мэргэнийг таалал төгссөний дараа Алун-Гоо эр нөхөргүй атал 3 хүү төрүүлсэн нь түүнийг зөрчилд оруулж, улмаар хүүхдүүдийн хооронд эв эе эвдрэх шалтаг үүсч болох үүд хаалга нээгдэж байгааг хурц гэгээн ухаандаа тольдон ухаарч хойшдын эмгэнэлт явдлаас зайлахын тулд тэр үеийн хүмүүсийн үзэл санаанд нэвт шин-

гэсэн Тэнгэрийн заяаны үзлийг ухаалаг ашиглан үр хүүхдээ сургаж, улмаар тэднийг улс орны эзэд болох ёстой хэмээсэн эцсийн зорилгод түлхэж чадсанд Алун-Гоо эхийн их гавьяа оршино. Таван сумаар таван хүүхдийн эв найртай байх цаашдын замыг заасан Алун-Гоо эх Хожим төрсөн гурван хүүгээ «ер бус гэрлээс хэвлийд шингэсэн Тэнгэрийн хөвгүүд»³ болгон дүрслээд жирийн хүнтэй яаж адилтгаж болох билээ. «Хамгийн хаан болсон хойно харц хүн»⁴ сая учрыг мэднэ бизээ гэснээр Улсын хаан болгох тодорхой зорилгод үр хүүхдээ чиглүүлж чаджээ. Алун-Гоо эхийн эл явдлыг Жамбалдоржийн «Болор толь» зохиолд: «...Алун хатны зүүдэнд наран, саран биед орох ба алтан хуягт тэнгэр ирж биеийг сахих тэргүүтнийг зүүдлэн байгаад төрсөн хөвүүн нь Бодончар»⁵ гэсэн бол Дандины «Зохист аялгууны тольд»:

«Амраг нөхөр лүгээ хагацсан Алун-Гоо хатан
Амгалан нойрны зүүдэнд тэнгэр лүгэ наадан цэнгэж
Алжаал тайлахын сацуу хөвүүн нэгэн олдсон нь

Анхан төрсөн цагаас баатар сэцэн Бодончар»⁶ гэж дүрслэн өгүүлжээ. Бодончар ийнхүү Алун-Гоо эхийн ариун нуруунаас гэрлээс бий болон төрсөн болохоор тэднээс салбарлан үржиж өссөн монголчуудыг «Нирун» гэж нэрлэх болсон нь ойлгомжтой.

Бодончар эхийг таалал төгссөний хойно Бурхан халдун уулын Түнхэлэг горхиноо нүүдэллэн ирсэн нэг бүлэг урианхай иргэдийг «толгой шийр цөм адил»⁷ тул «бие тэргүүтэй, дээл захтай сайн»⁸ хэмээн эзлэн авч захирснаар «тухайн үедээ монгол аймгуудын толгойлогч, хан»⁹ болжээ. Тэр маш эрэлхэг зоригтой учир «хамгийн хаан Богд эзэн», «Шалгарсан дээд мэргэн хүн»¹⁰ болсноор Алун-Гоо эх түүхэнд нэрээ үлдээсэн ухаантай, сэргэлэн, гоо үзэсгэлэнтэй хатан байсан төдий биш их Богд эзнийг төрүүлсэн Эх Дагина болжээ. Алун-Гоо эх ухаан сэргэлэн, сэцэн оюун билэгтэй эх байсан төдийгүй түүний гадаад үзэмж алсаас гэрэлтэн үзэгдэх үнэхээр гоо үзэсгэлэн байсныг «мухлаг тэргэнд сууж яваа нэг сайхан охин...хүний гэргий болоогүй бол Добу мэргэн дүү чамд гуйж гэргий болгоё»¹¹ хэмээн Дува сохор уулын оройгоос хараад хэлснээс тодорхой бөгөөд түүний гоо үзэсгэлэнгийн тухай Ишбалжирын номд: «Хори түмэд язгууртны Алун-Гоо нэртэй охины нүүр Махлаг өргөн, шүд тэгш цагаан, нүд уужим, хамар өчүүхэн өндөр, бие нүнжлэг, үс хийгээд өнгө гуа үзэсгэлэнт, дуу яруу, хөлс идэш багатай, нууцын орон зөөлөн зохист, үс тачирхан их заан явах мэт төгөлдөр...нүд, бие, сормуус шар үсгүй, бие нарийн цэх, шулуун хэмээхүй билэг чанар бүрдсэн...»¹² гэж тодорхойлсон байдаг.

Ийнхүү үр хүүхдээ эв найртай өсгөж хүмүүжүүлэх монгол үндэстний онцлог аргын эхлэлийг тавьж, түүхэнд нэрээ үлдээсэн Богд эзнийг төрүүлж өсгөн гавьяа байгуулсан, ухаант эх, гоо үзэсгэлэнт Алун-Гоо хатныг Монголын түүхэн дэх Эх дагинасын анхных гэж үзэх ёстой болов уу.

Монголын түүхэнд гардаг хоёр дахь Эх дагина бол Чингис хааны эх Өэлүн үжин юм. Есүхэй баатар Олхуноуд аймгаас эхнэр аваад буцаж явсан Мэргэдийн их Чилэдүгийн «гуа үзэсгэлэнт хатан»¹³-ыг булаан авч эхнэр болгосон нь Өэлүн үжин байлаа. Өэлүн үжин ухаан их, санаа сайхан, уужим сэтгэлт, баатарлаг нэгэн байсныг түүний хуримын замаасаа булаагдах үедээ анхны нөхөр Чилэдүгийн хэлсэн үг гэрчилдэг. Тэр Мэргэдийн их Чилэдүгийн гэргий болох гэж явах замдаа эр нөхөрт нь аюул учирч амь нас алдаж болохыг ойлгон «...Тэр

гурвын царай сэжиглэмээр байна. Чиний аминд хор хүргэж болно. Амьд мэнд үлдвэл эхнэрийг олоход бэрхгүй. Мухлаг тутам охид бий. Тэрэг тутам хатад бий. Миний мэт өнгөт эхнэр олнодоо... Миний үнэрийг үнсч яв гэж цамцаа тайлж өгөв»¹⁴ гэснээс Өэлүн эхийн царай зүс төдийгүй, ухаан санаа хичнээн ариун, уужим сайхан хүн болохыг ойлгож болно. Өэлүн үжин Есүхэй баатарт ирж дөрвөн хүү, нэг охин төрүүлсний анхны хүү нь Монголын нэгдсэн төрийн их эзэн хаан Чингис байлаа,

Өэлүн үжин авааль нөхөр Есүхэйг татаруудад хорлогдон нас барсан цагаас улс орны эв нэгдэл, эрх чөлөө, тусгаар тогтнолыг бүхнээс эрхэмлэн хатуужин зүтгэсэн алдарт Эх байв.

Хятадын Сүн улсын (MT 960— 1279) үед Монголын олон аймагт Өэлүн эх «Хүүхэн хан» гэж алдаршсан бөгөөд Есүхэй хорлогдсоны дараа «Өэлүн эх Чингис хааныг бага байхад Монголын олон аймгийг захирч, хил хязгаараа бэхжүүлж, жил бүр цэрэг хөдөлгөн Сүн улсыг чичрүүлж «...чоныг алс хөвж барьдаг. Сүрэгт орсон цагт завддаг буюу. Цэргийг холоос угтан тосч тулдаг. Хоргод орсон цаг хүчирдэг буюу...Цэрэг бага хамаа байхгүй, чадал хэрэгтэй биш үү? Улсаа засах Та эрсүүд, удмаа сахих манай эхнэрүүд биш үү? Хэдий цөөхөн гэвч нэг сэтгэл их, хэтэрхий олон байвч нэгдэхгүй бүтэх үү?»¹⁵ хэмээн улс орны тусгаар тогтнолыг эв нэгдлээр бүтээдгийг сурган хэлж байсан нь өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй байна.

Өэлүн эх энэ үзэл санаагаараа үр хүүхдээ хүмүүжүүлж, борви бохисхийлгүй зүтгэсээр бодол санааныхаа эцсийн зорилгод хүрч чадсан юм. Өэлүн эх, Алун-Гоо эхэд тохиолдсон шиг үр хүүхдийн эе эвдрэх бэрхшээлийг бие сэтгэлээр хатуужин туулж өнгөрөөсөн хүн. Есүхэйн нэг Эхнэр Сочигэлээс төрсөн Бэгтэр, Бэлгүтэй хэмээх хоёр хүү Өэлүн эхээс төрсөн Тэмүжин, Хасар хоёрын агнасан болжмор, загас зэргийг булаан авснаас болж Тэмүжин, Хасар хоёр Бэгтэрийг харван алдаг. Энэ жигшүүрт явдлаас болж Өэлүн эх «эртний үгийг иш татаж, өвгөдийн үгийг үндэс болгож хөвүүдээ машид буруушаан зэмлэснийг»¹⁶ Нууц товчоонд хүний ой тойнд ортол шүлэглэн өгүүлсэн байдгийг бид сайн мэдэх тул нуршсангүй. Есүхэйг нас барсны дараа хар нутаг дээр хаяж нүүсэн Тайчуудаас өшөөгөө яаж авъя даа гэж ядаж байхад бие биенээ хөнөөсөн нь Өэлүн эхэд туйлын хүнд цохилт болсон болохоор «Сүүдрээс өөр нөхөргүй, сүүлнээс өөр ташуургүй» хэмээн хатуу чанга зэмлэсэн нь үйл явдлын цаашдын өрнөлт, үр хүүхдийн ухааралд их нөлөө болсон гэж үзэх үндэстэй. Үр хүүхдээ өсгөж, үндэс угсаагаа аврах их үйлийг цээжиндээ хадгалсан Өэлүн эх гадна, дотны дайсны хавчилт хяхалт, сүрдүүлэг, доромжлолын өмнө өвдөг үл сөхрөн, ой шугуйд нуугдаж, орон гэрээ орхиж, Онон мөрнийг өгсөн уруудан, өдөр шөнийг аргацаан өнгөрөөж, эгмээс нь татаж, эрийн зэрэгт хүргэсэн, хүзүүнээс нь татаж хүний зэрэгт хүргэсэн суут хөвгүүд нь амьдрал тэмцлийн дунд өсөн бойжиж «засагтан сайд, хаад ноёд» болсон билээ.

Өэлүн эх үр хүүхэд, үндэс угсааныхаа эв нэгдлийг эрхэмлэн сахигч, сайн сурган хүмүүжүүлэгч, алдар хүндэт эх байсныг түүний Чингис, Хасар хоёрт хэлсэн үг гэрчилдэг. Нэгдсэн Монгол улсыг байгуулж, Тэмүжин Чингис хаанд өргөмжлөгдөөд байсан үед Хонхотны Мэнлиг эцгийн хүү Хөхөчү бөөгийн «Зөн» ятгалгаас болж Чингис хаан дүү Хасараа хаан ширээнд санаархав гэж хардан барьж байцааж буйг мэдсэн эх Өэлүн шөнөжин явж очдог. Чингис хаан эхээ үзээд эмээн зайлахад Өэлүн эх ихэд уурлан бухимдаж «...Одоо дайсныг дарж төгсөв гэж Хасарыг үзэн ядаж байна уу?»¹⁷ хэмээн «хоёр

хөхөө гаргаж, хоёр өвдөг дээрээ барьж, хөхсөн хөх чинь энэ байна. Хавиргаа хадран хазагчид, хүйгээ хүчирхэн тасдагчид!»¹⁸ хэмээн ихэд зэмлэхэд Чингис хаан эхийн уурыг амаржуулаад «Эхийг хилэгнэсэнд би айхын ихээр айж, ичихийн ихээр ичив. Бид одоо ингэхээ больё»¹⁹ гэж буй нь хэдий хаан хүн боловч хичнээн их хүмүүжилтэй, ахлах, дээдлэх ёсыг эрхэмлэдэг байсны тодорхой гэрч мөн. Өэлүн эх өөрөөс төрсөн үр хүүхдээ ийнхүү хүмүүжүүлээд зогсоогүй, дайсны нутаг дээр орхигдсон өнчин өрөөсөн үр хүүхдийг ч авч өсгөж хүмүүжүүлж байсан ухаант эх билээ. Тэр Мэргэдийн нутгаас Хүчү, тайчуудын бэсүдийн нутгаас Хөхөчү, Татарын нутгаас Шиги хутуг, урхиний нутгаас олж авсан Борохул дөрвөн хөвүүнийг асарч «өдөр үзэх нүд, шөнө сонсох чих» болгож яваарай хэмээн Чингист баатар туслагчид болгон хүмүүжүүлж өгч байна. Энэ тухай Чингис хаан «Миний эх Шигихутуг, Борохул, Хүчү, Хөхөчү та дөрвийг дүрвэсэн иргэний нүүсэн нутгаас олж

«Хөдөөнөөс олж
Хөлдөө бүйвээлж
Хүмүүжүүлэн тэжээж
Хүзүүнээс чинь татаж
Хүний зэрэг болгож
Эгэмнээс чинь татаж
Эрийн зэрэгт оруулж

хөвүүд бидний нөхөр, сүүдэр болгоё гэж тэжээжээ» хэмээн өгүүлснээс тодорхой харагддаг.

Өэлүн эхийн өсгөж бойжуулсан үр хүүхэд Монгол туургатныг нэгтгэн дэлхийн хүчирхэг их гүрэн болгож чадсан явдал бол ухаант эхийн уужим сэтгэл, үр хүүхдээ дээд зэргээр хатуужуулан хүмүүжүүлсний их гавьяа зүтгэл билээ. Цэргийн эрдэмд гарамгай суралцсан, мэргэн ухаан, хурц сэргэлэн ой, хэнийг ч болов өөртөө дагуулан жолоодох их чадвар, аймшиггүй зориг тэвчээр, уужим сэтгэлтэй Чингис баатрыг төрүүлж Монголын Нэгдсэн төр улс байгуулж чадсан түүхэн гавьяа, үзэл санааны үндэс нь Өэлүн эх болохоор түүнийг бусдаас илүүгээр **Улсын Эх дагина** гэж нэрлэх нь зүйд нийцнэ гэж үзэж байна.

Монголын түүхэнд гардаг гурав дахь Эх дагина бол Чингис хааны хар багаас хайрлан хань ижил болгосон Бөртэ үжин мөн.

Есүхэй баатар Тэмүжинг есөн настай байхад Өэлүн эхийн төрхөм олхуноуд иргэнд зорьж, хөвүүний нагац нараас охин гуйя хэмээн дагуулж явах замдаа Хонгирадын Дэй Сэцэнтэй уулзахад тэр «Энэ Хөвүүн чинь нүдэндээ галтай, нүүртээ гэрэлтэй хөвүүн байна. Есүхэй худ миний гэрт оч. Надад өчүүхэн охин бий. Та үз» гэж дагуулан очсоноор Тэмүжин «нүүртэй гэрэлтэй, нүдэндээ галтай», нэг нас эгч Бөртэ үжинтэй сүй тавьж хожим хойно амьдралын түмэн нугачаа, мянган бэрхшээлийг хамт туулан дөрвөн хүү, таван охины эцэг эх болж²⁰ билээ. Бөртэ үжин 1178 онд Тэмүжинтэй хуримласан боловч удалгүй Мэргэдэд баригдаж багагүй хал үзжээ. Бөртэ үжин Их Монгол улсыг нэгтгэх гэсэн Тэмүжиний их үйлсэд бүх хүч чадал, оюун ухаанаа дайчлан оролцсон нь түүний үр хүүхдээ өсгөж, өрх гэрээ өөд татах ажилд бэрхшээл учруулаагүйгээр барахгүй харин ч Чингис хааны санах сэдэхэд санаа өгч, сайн үйлсэд түшиг болсон буянтай хэрэг байв. Иймээс ч Бөртэ үжинг Чингис хааны журамт гэргий, энэрэлт эх төдий биш, «дайчин үйлсийн нь хань, дархан төрийн нь түшиг»²¹ байсан гэж зүй ёсоор үнэлдэг билээ. Хожим 1265 онд Бөртэ

үжинд «Богдын түшээ гэгээн, Ивээлт хатан»²² цол олгосон нь энэ бүхний баталгаа мөн. Бөртэ үжингээс төрсөн дөрвөн хүүгийн 3-р хүү Өгөдэй 1219 онд хаан эцгийн суудлыг залгамжилсан явдал Бөртэ үжинг Их Богд хааныг төрүүлж өсгөсөн Эх дагина болсныг гэрчилсэн билээ. Чингис хаан Сартаул (Туркестан) улстай байлдахаар мордох үед Есүй хатан «...Уул мэт бие чинь нурж одвол улс олон монголыг чинь хэн захирах юм бэ?...» гэсэн санаагаар залгамжлагчийн асуудал хөндөн тавьсанд Чингис: «үхэл надаас тойрох мэт үнэхээр түүнийг санасангүй» хэмээн «Хөвүүдийн ах Зүчи юу хэлэх вэ?» гэхэд Цагаадай: «Зүчийг та томилох гэж байна. Энэ мэргэдийн орхидост бид захирагдах гэж үү?» гэж хэлснээс хөвгүүдийн хооронд зөрчил үүсдэг билээ. Гэтэл үнэн хэрэг дээр Бөртэ үжин хэвлийдээ сар болсон хүүхэдтэй байхдаа Мэргэдэд баригдаж²³ явсан тухай сурвалжид гардаг. Цагаадайн үгийг сонссон Чингис хаан «Зүчийг ингэж хэлж яаж болох вэ? Хөвүүдийн маань ахмад нь Зүчи биш үү. Хожим ингэж бүү хэлтүгэй»²⁴ гэж зарлиг буулгасан байдаг. Энэ үед Хөхөчос Цагаадайд хандан.

«...Хатан сайхан эхийнхээ
Халуун элгийг хөргөж
Хайрт зүрхийг гомтгож
Тос шиг санааг царцуулж
Сүү шиг сэтгэлийг ээдүүлэх
Чалчаа муу үгийг
Цагаадай чи хэллээ.
Бүлээн элэг нэгтэй
Бөртэ хатны хүүхэд биш үү...
Хэвлийдээ тээсэн эхийн
Хэтэрхий ачийг мартаж
Хэдэр үгээр гомтговол
Хэзээ ч баясгаж чадахгүй
...Хаан богд эцэг чинь
Хамаг улсаа байгуулахдаа
...Шүлсний хөөсөөр ундалж
Шүдний махаар хооллож
Магнайн хөлсийг гоожтол
Мацаж чармайж явахад
Хайрт хатан эх чинь

Хамт зовж явжээ... »²⁵ гэж хэлсэн тухай Монголын нууц товчоонд гардаг. Үүнээс үзвэл Бөртэ үжин үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх, хань нөхөртөө халамж анхаарал хандуулах, төр улсаа төвшитгөх их үйлсэд хар багаасаа Тэмүжиний хамт зүтгэж чармайж явсныг харуулна.

Монголын хаант улс байгуулагдсаны дараа Чингисийн эцэг Есүхэйн дэргэд байсан Мэнлэг эцгийн дунд хүү Хонхотон аймгийн Хөхөчү тэв Тэнгэр гэгч бөө хар санаа өвөрлөж, ёс бус үйл явдлаар Чингис хааныг буруу замд татах гэж оролдон, их хэргийг эвдэхээр санаархаж улмаар Чингисийн дүү Хасарыг барьж зодон, Тэмүгэ Отчигин дүүг нь хүчээр өөртөө мөргүүлсэн зэрэг дур зоргоор авирлах явдал гаргасан үед Бөртэ үжин «...орон дотроос өндийн сууж, хөнжлийн захаар өвчүүгээ бүрхэж...нулимас унаган...»²⁶ Чингист учир явдлыг ухуулан хэлж, үнэн зөвийг ойлгуулж, хэрэг явдал цаашид даамжрахыг зогсоож ёс журмыг эрхэмлэх, хууль дүрмийг сахих, төрийг төвшитгэх, олныг амаржуулах явдалд чухал түлхэц үзүүлж байсан бай-

даг. Бөртэ үжин эхийн үр хүүхдээ гэх халуун сэтгэл, сайхан санааг гомдоож болохгүй гэсэн санааг Нууц товчоонд өгүүлэхдээ:

«...Бохиры чинь арилгаж
 Борвий чинь сунгаж
 Эрийн зэрэгт оруулж
 Эмээлийн дөрөөнд хүргээд
 Энхрий хөвүүд та нарын
 Эрхэм сайныг үзье гэж
 Эх чинь одоо бодож байна.
 Наран шиг гэгээн ухаант
 Навч шиг дэлгэр сэтгэлт
 Сайн хатан эхийнхээ

Санааг бүү гомдуул!» гэж шүлэглэн дуулсан байдаг. Энэ бүх баримт Бөртэ үжинийг Монголын түүхэнд томоохон нөлөө үзүүлсэн Эх дагина байсныг гэрчилнэ.

Монголын түүхэнд гардаг дөрөв дэх Эх дагина бол Мандухай сэцэн хатан мөн.

XV зууны Монголын төрийн тогтворгүй байдлыг төвшитгөсөн эмэгтэй баатар бол Мандухай сэцэн хатан байв. Тэр улс төрийн тэмцэлд гуйвшгүй эрс чанга, зориг, сэцэн мэргэн оюун бодол, зоримог дайчин чанараараа шалгаран гарч Чингис хааны алтан ураг Батмөнх Даян хааныг ширээнд залж улс орноо амаржуулсан түүхэн гавьяатай билээ.

1368 онд Юан гүрэн мөхөж Тогоонтөмөр хаан Бээжингээс ухран гарсны дараа Монголын улс төрийн байдал 100 орчим жил туйлын тогтворгүй, болж, феодалуудын хооронд хагарал гарч, газар нутаг булаалдаж, өөр өөрийн сүр хүчээ ихэсгэх зорилгоор хоорондоо байлдаж, өөрсдийгөө хаанд өргөмжилж, бие биенээ захирч чадахаа байсан яг тэр үед улс төрийн тавцан дээр Мандухай хатан гарч ирсэн юм. Энэ үед ард түмэн дотоодын дайн дажин, хагарал бутрал, гадны түрэмгий санаархлаас улс орны эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалах, өөр хоорондоо нэгдэх, амар төвшин амьдрах хүсэл эрмэлзэл дүүрэн болсон байв.

Мандухай бол Мандул хаан бага хатан бөгөөд Түмэдийн Чорсбай Төмөр Чинсангийн охин билээ. Мандул хааныг нас барсны дараа Мандухайтай гэрлэж хаан болох гэсэн Хорчины залуу сайхан ван Өнөболдын хүсэлтийг талаар болгон буцаагаад 1470 онд Батмөнхийг 7 настай байхад хаан суудалд залж²⁷, түүнтэй ураг холбосноо Мандухай зарласан нь Монгол улсыг нэг эзний гарт нэгтгэх алсын хараатай аугаа их эх оронч үзэл байсан билээ. Тэр Монголын тархай бутархай феодал эздийг зэвсгийн хүчээр хумин хурааж, биедээ хуяг дуулга өмсөн, Монголыг нэгтгэхэд хамгийн их саад болж байсан Ойрадыг дайлан дагуулж нэгтгэсэн юм. Монголыг нэгтгэхэд ухамсарт бүх амьдралаа зориулсан Мандухай сэцэн хатан Даян хааныг арьсан уутанд хийж үүрч, дүүрч, дайны талбарт амаржиж хүртэл явсан нь Чингис хааны дараа орох түүхийн их баатар байсныг гэрчилнэ. Энэ тухай Өвөр Монголын судлаач Дорнотив «...Дотоод, гадаадын түүхэнд Мандухай лугаа зэрэгцэн чадах эмэгтэй байсныг олж үзсэнгүй»²⁸ гэж тэмдэглэсэн нь бодит үнэлэлт мөн.

Мандухай сэцэн хатан Монгол үндэстнийг нэгтгэн Чингис хааны алтан урагт төрийн жолоо атгуулахын тулд Даян хааныг 4 настай байхад өөртөө авч, түүнийг өсгөж, хүмүүжүүлж, ирээдүйн хааны үйл амьдралд сургаж байсан нь түүний хамгийн гол гавьяа мөн. Тэрбээр

Батмөнх Даян хааны гарт бүх Монголыг хураан зангидаж өгөөд сая санаа амарч, Даян хаан нас биед хүрч буйд баярлан «...Цагаагчин могой жил (1473 онд) олон сайд түшмэдийг дуудан ирүүлж

«...Бурхан тэнгэрийн ивээлд шүтэж
 Богд эзний үрийг тэтгэн
 Буруу гэмтнийг гэсгээн оруулж
 Бутарсан төрийг хашилаа.
 Эзэн хаан та бие өссөн тул
 Иргэн түшмэдийг танд тушаасугай,
 Энэнээс хаан түшмэд засгаа баригтун
 Эм хүн надад юун хэрэг»²⁹ гэж хэлээд төрийн эрхийг шилжүүлж өгчээ.

Үүнээс үзэхэд Мандухай сэцэн хатан бол Бүх Монголын хаан ширээнд суусан Даян хааныг багаас нь гардан авч, өсгөж, хүмүүжүүлж, хайрлаж нэг талаар эх нь нөгөө талаар хатан нь болж явсан улс төрийн гарамгай ухаантан байсан учир түүхэнд дөрөв дэх Эх Дагина, Улсын эх дагина гэж өргөмжилбөл хоёр дахь хүн нь юм.

Өмнө үгүүлснээс үзвэл Монгол улсыг нэгтгэн захирч байсан Богд эзэн хааныг төрүүлж өсгөсөн Эх дагинасын тоонд Алун-Гоо, Өэлүн үжин, Бөртэ үжин, Мандухай сэцэн хатан нар гол байрыг эзлэн орох ёстой. Ер нь Монголын түүхийн хэмжээнд авч үзвэл эх дагинасын тоонд орох алдарт эмэгтэйчүүд цөөнгүй байдаг. Тэр бүгдийг энд үйл явдал, үзэл бодол, үнэн бодит түүхээр сэргээж гаргана гэвэл их хугацаа шаардсан том ажил болох тул товч авч үзсэн нь энэ болой. Хэрэв түүхийг сөхөж үе бүрийн эхчүүдийг нарийвчлан тодотговол монгол улсын эрх чөлөө, тусгаар тогтнол, эв нэгдэл, ард түмний амгалан тайван байдал, сайн сайхны төлөө халуун амь бүлээн цусаа үл хайрлан зэвсэг барин тэмцэхийн зэрэгцээ үр хүүхдээ эх орон, ард түмэндээ хэрэгтэй хүн болгон хүмүүжүүлэх талаар үлгэр үзүүлж явсан олон шилдэг эхчүүдийг дурдаж болно.

Ялангуяа энд өмнө дурдсан эхчүүдээс гадна Инжинашийн Хөх судар түүхэн романд гардаг Хонгорзул, Солонгуа, Сайхангүр, Голын саран гүнж, Бөртгөлжин зүсэн хатан зэрэг баатарлаг эхчүүд, Монгол улсын нэгдлийн төлөө Манжийн эсрэг зэвсэг барин тулж, Туул голын Зуун модны газар дайсны суманд амь эрсэдсэн баруун Монголын Галдан бошготын гэргий Анударь хатан, Монголын анхны богд Өндөр гэгээн Занабазар, Түшээт хан Чихундорж нарын эх Ханджамц, манай хувьсгалын жолоодогч их жанжин Сүхбаатарын эх Ханд гээд олон сайхан Эх дагинас түүхэнд зохих байраа эзлэх учиртайг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Монголын түүхийг урагш ахиулан, алдар нэр нь түүхэнд үлдсэн хаадыг төрүүлж, тэдний үйл ажиллагаанд түлхэц өгсөн эдгээр эх Дагинасын үйл ажиллагаа «Эмэгтэй хүнд гурван эр бий. Анхны эр нь алтан төр. Дараахь эр нь ариун нэр. Үлдсэн эр нь авсан эр мөн. Алтан төрийг хатуужин дагавал Ариун нэр бэлэн болно. Ариун нэрийг бэхэлж чадвал Авсан эр ангид үл одно»³⁰ гэсэн Чингис хааны сургаал гарах үндэс болж энэхүү сургаалаар Чингис хаанаас хойшхи эх оронч эмэгтэйчүүд замнаж ирсэн нь тодорхой ажээ. Үүнээс үзвэл Монгол эмэгтэйчүүдийн алтан төрийн бэх батын төлөө, алдар нэрийн ариун сайхны төлөө, авсан нөхөртөө түшиг болохын төлөө нэг амьдрах насаа зориулж:

«Хацрыг жадалж байвч
Харсан нүдээ цавчдаггүй
Хар цусаа урсч байвч

Харьж огт буцдаггүй»³¹ баатарлаг хөвгүүдийг хүмүүжүүлж байсныг түүхэн үйл явдал тодорхой гэрчилнэ. Монголын нэгдсэн төрийн төлөө амь хайргүй тэмцэж явсан эрэлхэг дайчин, баатарлаг эрчүүд, хаад, богдыг төрүүлж өсгөсөн гол хүмүүс нь болох «Эх дагинас» үнэхээр ухаалаг сайн хүмүүс байсныг дайсан хүртэл үнэлж байсныг Жамухын хэлсэн үг гэрчилдэг. Тэр Тэмүжинд баригдаад байхдаа: «Сэргэлэн баатар чамд Сэцэн эх заяажээ. Эрэлхэг баатар андад эрдэмтэн дүү нар төржээ», «Асгарах цусыг гаргалгүй, алуулж өршөө намайг»³² гэж яах ч аргагүй ялагдах учиртайгаа хүлээн зөвшөөрч байгаагийн цаана баатарлаг богд эздийг хүмүүжүүлсэн Эх дагинасын алдрыг бахархан биширсэн өнгө аяс тодорхой харагддаг.

Монголын түүхэнд алдаршсан Эх дагинасын тухай, тэдний үр хүүхдээ хүмүүжүүлж байсан арга барил, хүүхдүүдийн нь хүмүүжлийн тухай нэлээд материалтай танилцаж үзэхэд дараах гол дүгнэлтийг гаргаж болмоор байна. Үүнд сайн эх өсгөж хүмүүжүүлсэн, жинхэнэ ард түмний удирдагч хүн хүнд хэцүү, ядуу зүдүү амьдрал, зовлон бэрхшээлийг хар бага наснаас бие сэтгэлээр туулж, хатуужил тэвчээртэй болж, байгаль нийгмийн өөрийн нь шалгарлаар бие чийрэг, ухаан санаа хурц, бодол сэтгэл гүн, үг хэл найрамдуу, олон түмний дунд ямагт амьдарч чаддаг, эрэмгий дайчин, ихээхэн авьяаслаг, туйлын ажилсаг олон чанараараа бусдаас товойн гарч ирсэн нь ажиглагдана.

Хоёр дахь дүгнэлт нь бага наснаас бэлэн юман дээр эрх таваараа жаргаж өссөн хүн хэдий ухаантай, эрдэмтэй, сайн хүмүүжилтэй ч байсан улс орны удирдагч байж чадахгүй, ямагт олон түмнээс хөндийрч тасардаг, ганц биеийн хэмжээгүй эрх ямба, жаргал цэнгэлийг эрхэмд үзэн эх орон, ард түмний эрх ашигт хохирол учруулдаг, ажилсаг тэвчээртэй, ухаалаг олон чанар нь сулран алга болдог нь амьдралаар нотлогдож байна. Ингээд Монголын түүхэнд нэр алдраа мандуулсан эмэгтэйчүүд Эх дагинасын тухай өгүүлсэн энэхүү өгүүллээ

Түмэн үеийн их түүх бүтээлцэж
Төрийн баганы гэрэлт нэгэн хөшөө болсон
Эх оронч, хөдөлмөрч, баатарлаг
Эрх чөлөөг эрхэмлэгч, дайчин уламжлалаар
Машид дэлгэрэх монгол үрсээ хүмүүжүүлсэн
Манай үндэстний үзэсгэлэн гуа эхчүүд
Алдар цуут Эх дагинас бүхний өмнө
Ачийг санан бишрэн сөгдмү би» гэсэн үгээр төгсгөө.
Сайн үйлс дэлгэрэх болтугай.

¹ Х. Пэрлээ. Нууц товчоонд гардаг газар усны зарим нэрийг хайж олсон нь УБ. 1958, 4-р тал

² Мансан. Монголын нууц товчоо. Хөх хот. 1985. 5-р тал 1 боть. 1952, 160-р тал

³ Рашид-Ад-Дин Судрын чуулган. 1 боть. 1952, 160-р тал

⁴ Монголын нууц товчоо. Хөх хот, 1985. 7-р тал

⁵ Жамбалдорж, Болор толь. УБ. 1957. 13-р тал

⁶ Л. Хүрэлбаатар «Яруу найргийн онолын өв». «Цог» сэтгүүл, 1989. № 2, 87-р тал

⁷ Монголын нууц товчоо. УБ. 1976. 25-р тал

⁸ Мөн тэнд

⁹ Рашид-Ад-Дин Судрын чуулган. боть. 1952

¹⁰ Өвөр Монголын залуучууд. Хөх хот, 1989. № 20, 23-р тал

¹¹ Монголын нууц товчоо. УБ. 1976, 20-р тал

- ¹² Ишбалжир «Энэтхэг, Төвд, Хятад, Монголд буддын шашин дэлгэрсэн түүх Галбирваас модон нэрт оршвой зохиолын 301-ийн «А» талд
- ¹³ Монголын нууц товчоо, УБ, 1976 28-р талд
- ¹⁴ Монголын нууц товчоо. УБ. 1976. 29-р талд
- ¹⁵ Мөн тэнд
- ¹⁶ Лувсанчойдон. Монголын зан аалийн ойлбор. Хөх хот, 1981, 183-р тал
- ¹⁷ Монголын нууц товчоо. УБ. 1976. 39-р тал
- ¹⁸ Мөн тэнд 200-р тал
- ¹⁹ Мөн тэнд
- ²⁰ Мөн тэнд 201-р тал
- ²¹ Сайшаалт, Чингис хааны товчоон. Хөх хот. 1987. Доорд дэвтэр 1157-р тал
- ²² Мөн тэнд
- ²³ Мөн тэнд
- ²⁴ Сайшаалт, Чингис хааны товчоон. Хөх хот. 1987. 1163-р тал
- ²⁵ Монголын нууц товчоо. УБ. 1976. 216-р тал
- ²⁶ Мөн тэнд
- ²⁷ Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан. Хөх хот 1986 N 356-р тал
- ²⁸ Мөн тэнд
- ²⁹ Монголын хураангуй түүх. Хөх хот. 1986. 176-р тал
- ³⁰ Лу. Алтан товч. УБ. 1957. 11-р тал
- ³¹ Монголын нууц товчоо. УБ. 1976. 144-р тал
- ³² Мөн тэнд 162-р тал